



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ

6
АНГИ

ТҮҮХ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:



САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу балын харандаагаар будаарай.

1. Дараах он тооллын шугамд дэлхийн түүхийн үечлэлийг нөхөж бичнэ үү.



2. НТӨ 2017 он хэддүгээр зуунд хамаарах вэ?

- A. НТӨ XIX зуунд B. НТӨ XX зуунд
C. НТӨ XXI зуунд D. НТӨ XXI зуунд

3. Түүхийн эх сурвалжийг зөв ангилсан хувилбарыг сонгоно уу.

- A. Бичгийн, эд өлгийн, аман
B. Бичгийн, эд өлгийн, зурган
C. Эд өлгийн, аман, түүвэр олдворын
D. Бичгийн, эд өлгийн, түүвэр олдворын

4. Хүмүүс ургамлын үрийг газарт суулган тариалах болсноор газар тариалангийн аж ахуй аль үед үүссэн гэж үздэг вэ?

- A. Палеолитын үе B. Мезолитын үе
C. Неолитын үе D. Хүрэл, түрүү төмрийн үе

5. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу.

- Шинэ чулуун зэвсгийн үед ээрүүл хэрэглэн утас хийж, тэрхүү утсаараа тор сүлжих, томох юм уу нэхэж үйлдвэрлэдэг болжээ.
A. хөвөн B. даавуу C. торго D. цэмбэ

6. Доорх хариултуудаас Неолитын хувьсгалыг тодорхойлох хариултыг сонгоно уу.

- A. Нум сум бүтээж, ан агууруын олзоо нэмэгдүүлсэн.
B. Ан амьтны арьсаар хувцас хийж сурсан.
C. Галыг хэрэглэж сурч, хоол хүнсээ болгож идэх болсон.
D. Газар тариалан эрхэлж хүнсний хэрэгцээгээ хангасан.

7. Неолитын хувьсгал гарснаар хүмүүсийн амьдралд ямар шинэ өөрчлөлт гарсан бэ?


- A. Нүүдэллэн явах нь нэмэгдсэн.
B. Хувцас хийж өмсөх болсон.
C. Ан агууур хийх нь нэмэгдсэн.
D. Амьтныг гаршуулж өсгөж үржүүлдэг болсон.

8. НТӨ 8000 оны орчим ямар мөрний хөндийд хүмүүс анх суурьшин газар тариалан эрхлэж эхэлсэн гэж үздэг вэ?


- A. Амазон мөрөн B. Ижил мөрөн C. Шар мөрөн D. Эрчис мөрөн

9. Бичиг үсэг нь НТӨ 3200-3100 оны үед хаана үүссэн гэж үздэг вэ?
 А. Шумерт В. Египетэд С. Цинь улсад Д. Вавилонд

10. Доорх бүдүүвчийг нөхөж бичээрэй.



- A. Хөнгөн цагаан B. Алт C. Мөнгө D. Зэс
11. Дөрвөлжин булш нь Монголын аль хэсэгт элбэг тархсан бэ?
 А. Төв болон баруун Б. Төв болон зүүн
 С. Төв болон хойд Д. Төв болон өмнөд
12. Монгол нутагт өргөн тархсан оршуулгын дурсгал болох “Хиригсүүр”-ийн хамаарах хугацаа нь аль вэ?
 А. НТӨ II-I мянганд Б. НТӨ XIII-IV зуунд
 С. НТӨ III-II зуунд Д. НТ I-II мянганд
13. Доорх газрын зургийг ашиглаад Хиригсүүрийн өргөн тархсан бүс нутгийг олно уу.



- A. 1 болон 2 В. Зөвхөн 2
 С. 2 болон 3 Д. Зөвхөн 3

14. Тигр, Евфрат мөрөн хаанаас эх авч, хаашаа цутгадаг вэ?
 А. Умард Африкийн тэгш өндөрлөгөөс эх авч, Газар дундын тэнгист цутгадаг.
 Б. Хиндикуш, Гималайн нуруунаас эх авч, Арабын тэнгист цутгадаг.
 С. Төвөдийн тэгш өндөрлөгөөс эх авч, Шар тэнгист цутгадаг.
 Д. Бага Азийн өндөр уулсаас эх авч, Персийн буланд цутгадаг.
15. Зөв хариултыг нөхөж бичнэ үү.
 12 сартай он тооллыг анх зохиосон юм.
 А. Египетчүүд В. Шумерүүд С. Хүннүчүүд Д. Вавилончүүд



- 16.** Акадын эзэнт гүрний анхны хаан хэн бэ?
A. Хаммурапи B. Менис C. Аменхотеп D. Саргон
- 17.** Эртний Энэтхэгийн кастын тогтолцоонд хамгийн эрх мэдэлтэй лам санваартнуудыг юу гэж нэрлэдэг вэ?
A. Кшатри B. Вайши C. Шудра D. Брахман
- 18.** Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу.
..... хүүхдүүдээ 7 насанд нь цэргийн хуаранд хатуу бэрхийг зааж дуулгавартай, тэсвэр хатуужилтай болгон сургадаг байсан бэ?
A. Афинд B. Египетэд C. Спартууд D. Ромчууд
- 19.** Сенат, Патриц, Консул зэрэг нэршил нь аль улсын түүхэнд холбогдох вэ?
A. Эртний Ром B. Эртний Энэтхэг C. Эртний Грек D. Эртний Перс
- 20.** Эртний улсуудыг зөв харгалзуулна уу.

1. Маур эзэнт улс	a. Эртний Хятад
2. Жоу улс	b. Эртний Грек
3. Спарт улс	c. Эртний Энэтхэг

A. 1-а, 2-с, 3-б B. 1-б, 2-а, 3-с C. 1-с, 2-а, 3-б D. 1-с, 2-б, 3-а
- 21.** Хүннүгийн гол хүнс аль нь вэ?
A. Загасны мах B. Арвайн буудай C. Малын мах D. Цагаан будаа
- 22.** Модунийг шаньюй болмогц улс төрийн дарамт шахалт үзүүлж хурдан хүлэг, хайртай хатан болон газар нутгаа өгөхийг шаардсан улс нь аль вэ?
A. Юэжи B. Усунь C. Динлин D. Дунху
- 23.** Хүннү гүрнийг НТӨ 176-158 оны хооронд хэн захирдаг байсан бэ?
A. Түмэн шаньюй B. Модунь шаньюй
C. Зижу шаньюй D. Зүнчэн шаньюй
- 24.** НТӨ 48 онд Хүннүгийн дотор хаан ширээний төлөө тэмцэл өрнөж өмнөд, умард хэмээн хоёр хэсэгт хуваагдav. Уг үйл явдал одоогоос хэдэн жилийн өмнө болсон бэ?
A. 2072 жилийн өмнө B. 1976 жилийн өмнө
C. 2233 жилийн өмнө D. 1815 жилийн өмнө
- 25.** НТӨ 209 онд Түмэн шаньюйн хүү Модунь Хүннүгийн шаньюй болов. Уг үйл явдал хэддүгээр мянганы, хэддүгээр зуунд болсон вэ?
A. НТ I мянганы II зуунд B. НТӨ III мянганы III зуунд
C. НТӨ I мянганы III зуунд D. НТ II мянганы III зуунд